

ТӨЛӨӨЛӨН УДИРДАХ ЗӨВЛӨЛИЙН СОНГОН ШАЛГАРУУЛАЛТ ЯВАГДАЖ БАЙНА.

Эрүүл мэндийн яамнаас Улсын хоёрдугаар төв эмнэлгийн Төлөөлөн удирдах зөвлөлд ажиллах Олон нийтийн төлөөллийг сонгон шалгаруулах үйл ажиллагаа үргэлжилж байна.

Эрүүл мэндийн сайдын 2020 оны “Журам батлах тухай” А/565 дугаар тушаалаар баталсан журмын дагуу төрийн бус байгууллага, нийгэмлэгүүдээс ирүүлсэн нэр дэвшигчдийн материалын бүрдэлтэй танилцах хурал болон урьдчилсан сонгон шалгаруулалтын ярилцлагыг зохион байгуулсан. Улсын хоёрдугаар төв эмнэлгийн Төлөөлөн удирдах зөвлөлд ажиллах Олон нийтийн төлөөллийг сонгон шалгаруулалтад “Монголын нүүр ам судлалын залуу эмч нарын холбоо” ТББ, “Монголын пара бочигийн холбоо” НҮТББ-ын нэр дэвшигчид дараагийн шатанд шалгарсан. Журмын дагуу нэр дэвшүүлэн сонгох хурал 2026 оны 10 дугаар сарын 06-ны өдөр Эрүүл мэндийн яаман дээр зохион байгуулагдана.